



**Харилцаа холбооны зохицуулах хорооны
2023 оны ээлжит 04 дүгээр хуралдааны
мэдээлэл**

Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023 оны ээлжит 04 дүгээр хуралдааныг 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулав.

Зохицуулах хорооны 2023 оны ээлжит 04 дүгээр хуралдаанаар Харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалт, үйлчилгээг бүртгэхтэй холбогдсон журам"-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (Хорооны 2021 оны 74 тоот тогтоол); "ХХЗХ-ны тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээ эрхлэгчдийн 2022 оны үндсэн статистик, үзүүлэлтүүд"-ийн тухай танилцуулга; Харилцаа Холбооны Зохицуулах Хорооны 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэл, Хорооны 2022 оны хуралдааны тайлан, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, Байгууллагын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, зөвлөмжийн тухай; Тусгай зөвшөөрлийн тухай (ТЗ шинээр олгох, сунгах, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох тухай) асуудлыг хэлэлцэн хорооны 5 тогтоолыг батлан шийдвэрлэв.

Зөвшөөрлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад салбарын зохицуулалтын журам, баримт бичгүүдийг нийцүүлэх, давхардал, хийдлийг арилгах, шинээр батлах, нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болгох арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлж байна. Энэхүү ажлын хүрээнд болон эрх ашиг нь хөндөгдсөн үйлчилгээ эрхлэгчдээс ирүүлсэн санал, хүсэлтийн дагуу тус хорооны 2021 оны 74 тоот тогтоолын хавсралтаар баталсан "Харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалт, үйлчилгээг бүртгэхтэй холбогдсон журам"-д нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага гарсан болно. Иймээс тус 2023 оны ээлжит 04 дүгээр хуралдаанаар "Харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалт, үйлчилгээг бүртгэхтэй холбогдсон журам"-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай танилцуулга, уулзалт хэлэлцүүлгийн үр дүн, ирүүлсэн санал, саналын товчоо, тогтоолын төсөл, журамд нэмэлт өөрчлөлт оруулах санал, нөлөөллийн шинжилгээг тус тус хэлэлцэв. Энэхүү асуудлыг хэлэлцэх үеэр хорооны дарга, гишүүдээс гарсан үг үсэг, редакцын санал, зөвлөмжийг тусгаж, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9, 9.1.15 дахь заалтыг тус тус үндэслэн 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 30 тоот "Харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалт, үйлчилгээг бүртгэхтэй холбогдсон журам"-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай тогтоолыг батлав. Тогтоолд, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 74 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалт, үйлчилгээг бүртгэхтэй холбогдсон журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.2, 3 дугаар зүйлийн 3.1.1, 4 дүгээр зүйлийн Хүснэгт 1, 4.4, 4.6, 4.7, 4.10, 4.14, 4.16, 4.17, 5 дугаар зүйлийн 5.4.5, 5.4.12, 5.5.2.1-5.5.2.4 дэх заалтуудад холбогдох нэмэлт, өөрчлөлтийг тус тус оруулжээ. ХЗДХЯ-ны Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын бүртгэлд хянуулан нэмэлтээр бүртгүүлэхээр ХХЗХ-ны Даргын 2023 оны 01/444 албан тоотоор хүргүүлэв. ХЗДХЯ-ны Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 5306 бүртгэлтэй 2021 оны 74 тоот тогтоолд оруулсан 2023 оны 30 тоот тогтоолыг хянаж үзээд, тогтоолоор оруулсан нэмэлт, өөрчлөлтийг 2023 оны 04 дугаар сарын 23-ны өдөр ХЗДХЯ бүртгэсэн болно.

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023 оны ээлжит 04 дүгээр хуралдаанаар ХХЗХ-ны тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээ эрхлэгчдийн 2022 оны үндсэн статистик, үзүүлэлтүүд"-ийн тухай танилцуулгыг сонсож, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу эдгээр статистик мэдээ мэдээллийг байгууллагын цахим хуудаст байршуулах, олон нийтийн хэвлэл мэдээлэл, телевизээр сурталчлах, ЦХХХЯ болон ҮСХ-т хүргүүлэх арга хэмжээ авч ажиллахыг холбогдох бүтцийн нэгжид даалгав.

Зохицуулах хорооны 2023 оны ээлжит 04 дүгээр хуралдаанд Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, Төсвийн тухай хуулийн 8.9.8 заалт болон Хорооны даргаас өгсөн удирдамж, чиглэлийн хүрээнд ЗУХАГ болон Дотоод хяналт, аудитын албанаас нэгтгэн боловсруулсан Харилцаа Холбооны Зохицуулах Хорооны 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэл, Хорооны 2022 оны хуралдааны тайлан, тогтоол шийдвэрийн хэрэгжилт болон Байгууллагын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд ҮАГ-ын 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 07/560 тоот албан бичгээр ирүүлсэн аудитын дүгнэлт, зөвлөмжийн тухай асуудлыг хэлэлцэв. Хуралдаанаас хорооны дарга, гишүүдээс өгсөн удирдамж, чиглэлийн дагуу Зохицуулах хорооны 2022 оны санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайлан материаллаг алдаагүй, НББ-ийн тухай хууль, СТОУС-д нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан тул **“Өөрчлөлтгүй дүгнэлт”** бүхий санхүүгийн тайлангийн аудитын гэрчилгээ, зөвлөмжийг хүлээн авч, ҮАГ-ын ирүүлсэн дүгнэлт зөвлөмжүүдийг 2023 оны 3 дугаар улиралд багтаан хэрэгжүүлж ажиллах, зөвлөмжийн биелэлтийн тайланг Хорооны удирдлага, ҮАГ болон ЗГХЭГ-т тус тус хүргүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газар /З.Эрдэнэчулуун/, Дотоод хяналт, аудитын алба /Ц.Баярбаатар/, Санхүүгийн хэлтэс /Н.Халиунаа/-д тус тус үүрэг болгов.

ХХЗХ-ны 2023 оны ээлжит 04 дүгээр хуралдаанаар тусгай зөвшөөрлийн тухай (ТЗ шинээр олгох, хугацаа сунгах, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох тухай) холбогдох газар, хэлтсийн боловсруулсан танилцуулга, үнэлгээний дүгнэлт бүхий 4 тогтоолын төслийг хавсралтын хамт тус тус хэлэлцээд, тус хуралдаанаас 4 тогтоолыг хавсралтын хамт батлан шийдвэрлэсэн. Үүнд:

- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх заалт, 8.1 дүгээр зүйлийн 9 дэх хэсгийн 9.12 болон 9.14 дүгээр заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх заалтыг тус тус үндэслэн 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 31 тоот тогтоолын хавсралтаар 4 хуулийн этгээдэд 4 тусгай зөвшөөрлийг шинээр олгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.5 дугаар зүйл, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсэг, Радио долгионы тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийг тус тус үндэслэн 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 32 тоот тогтоолын хавсралтаар 8 хуулийн этгээдийн 13 тусгай зөвшөөрлийн хугацааг сунгасан;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалтыг үндэслэн 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 33 тоот тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийн оноосон нэрд өөрчлөлт оруулсан;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалт болон Брикланд ХХК-

ийн хүсэлтийг тус тус үндэслэн 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 34 тоот тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг хүчингүй болгон тус тус шийдвэрлэв.

Хуралдааны баталсан тогтоолын жагсаалт, холбогдох хавсралтыг <http://www.crc.gov.mn/main.php?cid=1&do=70&did=0> үзнэ үү).

Харилцаа холбооны зохицуулах хороо
2023-04-15